

## АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

**I. ТӨСӨВ:** Аймгийн төсвийн орлогод 4440.6 сая төгрөг орж, төлөвлөгөө нь 1.1 хувиар давж биелсэн байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс 2083.2 сая төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Сумдын төсвийн орлогын төлөвлөгөө 14 хувиар давж биелсний дотор Дарьганга сумаас бусад бүх сум биелзллээ.

Орон нутгийн төсвийн зарлага 3.1 тэрбум төгрөг болжээ.

Аймгийн дүнгээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 547.7 сая болсны дотор 364.5 сая төгрөг нь төрийн удирдлага, 137.1 сая төгрөг нь нийгэм бие хүнд үзүүлэх үйлчилгээ, 20.0 сая төгрөг нь боловсролын салбарт, 15.3 сая төгрөг нь эрүүл мэндийн салбарт, 10.8 сая төгрөг нь хөдөө аж ахуйн салбарт тус тус оржээ.

**II. МӨНГӨ, ЗЭЭЛ:** Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 13.8 тэрбум төгрөгт хүрсэн нь 2009 оны жилийн эцсээс 837 сая төгрөгөөр өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн хадгаламжийн хэмжээ 11.2 тэрбум төгрөг болсон нь 2009 оны жилийн эцсээс 3.8 тэрбум төгрөгөөр буюу 51.8 хувиар өссөний дотор бүх сумдад энэ үзүүлэлт нэмэгдсэн байна.

**III. ХӨДӨӨ АЖ АХУЙ:** Мал аж ахуй: Оны эхний төллөх эх малын 84.7 хувь болох 655.4 мянган эх мал төлөж, гарсан төлийн 97.0 хувь болох 639.9 мянган төл бойжиж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 104.2-75.4 мянгаар тус тус дээгүүр байна.

Оны эхний малын 1.6 хувь болох 28.4 мянган том мал зүй бусаар хорогдсон нь урьд оны мөн үеэс 2.1 дахин олон байна.

Түмэнцогт суманд оны эхний малын 10.6 хувь нь болох 6.4 мянган мал зүй бусаар хорогдоод байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж, МИДаатгалд хамрагдсан малчид нөхөн төлбөр авах босго давсан байна.

**Газар тариалан:** Үр тариа 80 га-д, төмс 58.8 га-д, хүнсний ногоо 27.2 га-д, тэжээлийн ургамал 94.4 га-д тус тус тариалалт хийлээ.

**IV. АЖ ҮЙЛДВЭР:** Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 13.8 тэрбум төгрөг болсон нь урьд оны мөн үеийнхээс 1.6 тэрбум төгрөгөөр доогуур байна.

Оны үнээр 58.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 2.2 дахин дээгүүр гүйцэтгэлтэй байгаагийн дотор уул уурхай, олборлох аж үйлдвэр, боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт 25.1-55.4 хувиар өссөн байна.

Гол нэр төрлөөс талх, нарийн боов, ул боов, хиам, нүүрс, молибдений баяжмал, дулаан, замын хавтан, боржуур, эсгийн үйлдвэрлэл урьд оны мөн үеэс нэмэгдсэн байна.

**V. БАРИЛГА, ТЭЭВЭР, ХОЛБОО:** Барилга: 428.9 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдээд байгаа нь урьд оны мөн үеэс 8.1 дахин өссөн байна.

**Тээвэр:** Тээвэр бүхий байгууллагууд 23.0 сая.тн км-ийн ачаа эргэлт, 12.0 сая.хүн км-ийн зорчигч эргэлт гүйцэтгэн, 3.0 тэрбум төгрөгийн орлоготой ажиллаж, өнгөрсөн оны мөн үеэс тээврийн салбарын үндсэн үзүүлэлтүүд давж биелсэн байна.

Автотээврийн улсын үзлэгийн дүнгээр 5614 тээврийн хэрэгсэл тоологдсон нь урьд оныхоос 469-өөр доогуур байгаагийн дотор оношлогоонд 4178 тээврийн хэрэгсэл орсон байна.

**Холбоо:** Холбоо ашиглалтын орлого 156.9 сая төгрөг болж урьд оны мөн үеэс 18.5 саяар доогуур байгаа хэдий ч хүн амаас орох орлого урьд оноос 5.8 саяар дээгүүр гүйцэтгэлтэй байна. Телефон цэгийн тоо 1021 болж урьд оны мөн үеэс 58 хувиар буурсан байна

**VI. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС:** Хэрэглээний үнийн индекс 6-р сард 2009 оны жилийн эцсийнхээс 5.1 хувиар өссөн хэдий ч урьд сарыхаас 4.2 хувиар буурлаа. Энэ нь Хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлэг, Гэр ахуйн тавилга, барааны бүлгийн үнэн 8.7-0.8 хувиар буурсан байна.

**VII. СОЁЛ, Боловсрол:** Мэргэжлийн урлагийн байгууллага 5 удаагийн тоглолтоор 12.0 мянган хүнд үйлчилж, 8.4 сая төгрөгийн орлоготой ажилласан нь урьд оноос 500.0 мянгаар дээгүүр байна.

Музейн нийт үзмэр 1758-д хүрч, үзэгчид 0.8 мянгад хүрч, 218.1 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь урьд оноос дээгүүр байна.

Нийтийн номын сангийн номын фонд 41.5 мянгад хүрч, 13.4 мянган уншигчидтай болсноор 451.1 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь урьд оноос 2.6 дахин өссөн байна.

2009-2010 оны хичээлийн жилд ЕБС-ийг 2.7 мянган хүүхэд өдрөөр төгссөний дотор бага боловсролыг 1120, суурь боловсролыг 1084, бүрэн дунд боловсролыг 520 хүүхэд эзэмшлээ.

**VIII. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ:** Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 1.9 тэрбум төгрөг болж төлөвлөгөө 8.1 хувиар давж биелэв. Харин сайн дурын даатгалын шимтгэлийн орлогоор 46.6 сая төгрөг орж, төлөвлөгөө тасарсан байна.

6085 өндөр настанд 2.9 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгожээ. Нийгмийн халамжийн сангаас 544.9 сая, хүний хөгжил сангаас 51.8 мянган хүнд 3.6 тэрбум, улсын төсвөөс 391.0 сая, нөхөн олговроор 1 хүнд 486.0 мянган төгрөгийг тус тус иргэдэд олгосон байна.

**IX. ЭРҮҮЛ МЭНД:** 576 эх амаржиж, 583 хүүхэд амьд төрсөн байна. 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 16 болж урьд оны мөн үеэс 9-аар олон байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 264 болж, урьд оны мөн үеэс 171-ээр доогуур байгаагийн дотор вируст гепатит, салхинцэцэг, тэмбүү, заг, трихоминиаз, бруцелллез зэрэг өвчнүүд буурсан байна.

**X. АЖИЛГҮЙЧҮҮД:** ХХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1199 болж, урьд оны мөн үеийнхээс 62 хүнээр нэмэгдсэн байна. Ажилгүйчүүдийн 68.3 хувь нь 16-34 насны залуучууд, 16.6 хувь нь дээд, 3.9 хувь нь тусгай дунд, 36.4 хувь нь бүрэн дунд, 8 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

1310 хүн шинээр бүртгүүлж, 1092 хүн ажилд орсон байна.

Шинэ ажлын байранд ажиллаж байгаа хүний тоо 353-т хүрчээ.

**XI. ГЭМТ ХЭРЭГ:** 85 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 14-өөр доогуур байна.

Гэмт хэргийн улмаас 21 хүн нас барж, 17 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 64.5 сая төгрөгийн хохирол учирсны 56.9 саяыг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 80 хүн холбогдон сэжиглэгдсэний 15 хувь нь согтуугаар, 17.5 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 1262 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 218 хүнээр доогуур байна.

**XII. МАЛЫН ИНДЕСЖҮҮЛСЭН ДААТГАЛ ТӨСӨЛ:** 2010 онд манай аймагт МИД төслийг хэрэгжүүлэх эрх авсан 4 даатгалын компанийн төлөөлөгчид 11 сумын 129 малчны 30.4 мянган малыг даатгалд хамруулан, 14.2 сая төгрөгийн хураамжийг МИД төслийн нэгжийн дансанд төвлөрүүлсэн байна. Дарьганга, Наран сумдын малчид даатгалд огт хамрагдаагүй байна.

**XIII. ТӨСӨЛ:** Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төсөлд хамрагдахаар 1.9 тэрбум төгрөгийн 102 төслийг иргэд бичиж ирүүлснээс аймгийн дэд комиссоор 65 төсөл дэмжигдэн, улмаар банкны шалгуураар орж, 44 581.8 сая төгрөгний 44 төсөл батлагдаж санхүүжилтээ аваад үйл ажиллагаагаа эхлээд байна.

**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас** 113 төсөлд 178.5 сая төгрөгийн зээл олгосны дотор Дарьганга 16 төсөлд 20.0 сая, Түмэнцогт 9 төсөлд 20.5 сая, Эрдэнэцагаан 15 төсөлд 24.8 сая төгрөгийн зээл авсан нь бусад сумдын зээл олголтоос дээгүүр үзүүлэлттэй байна.

**Тогтвортой амьжиргаа-II төслийн хүрээнд** хүрээнд аймгийн хэмжээгээр 49.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, тохижуулалтанд 25.8 сая, засварын ажилд 4.2 сая, тоног төхөөрөмж худалдан авахад 1.2 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

**XIV. ГАЗАР ӨМЧЛӨЛ:** Аймгийн хэмжээгээр нийт 4798 иргэн газар өмчилж авахаар өргөдөл гаргаснаас 1471 иргэнд 310.41 га газар өмчлүүлэхээр Засаг даргын захирамжаар шийдвэрлэж олгосон байна.

**XV. ДААТГАЛ:** Даатгалын компаниуд 2268 иргэнийг 8 төрлийн даатгалд хамруулан 59.2 сая төгрөгийг даатгалын хураамжаар оруулсан байна. Эхний 6 сард 190 хүнд 12.3 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгожээ.